

⁹ М. С. Горбачев. Перестройка и новое мышление для нашей страны и для всего мира. М., 1987 с. 168

¹⁰ Архив Маркса и Энгельса т. V л. 1938. с 219—232, т. VIII. л., 1946. с 147—154

¹¹ Н. Ишжамц, М. Пагма, К. Маркс монголын тухай «Дорнодахины судлалын асуудал» 1983. № 1 (8) УБ., 16—19 дэх тал, А. Минис. «Капитал» и некоторые аспекты аграрной проблемы в МНР — «Маркс и современность» М., 1968 с. 512

¹² К. Маркс, Ф. Энгельс түүвэр зохиол, II боть, УБ. 1970. 468 дахь тал

¹³ Richard T. La Piere. NY p. 519.

УЛС ТӨР, УЛСЫН БАЙДАЛ

ЗӨВЛӨЛТ-МОНГОЛЫН АРД ТҮМНИЙ АХ ДҮҮГИЙН БАРИЛДЛАГААНЫ ЭХ ҮҮСВЭР

Д. Б. УЛЫМЖИЕВ

Түүхийн ухааны доктор, профессор

Зөвлөлт Холбоот Улс, Бүгд Найрамдах Монгол Ард Улс шинэ амьдралыг цогцлон байгуулах найрамдал, хамтын ажиллагааны замаар нэгэнт 65 гаруй жил замнаж ирлээ. Зөвлөлт-Монголын харилцааны бүхий л түүх нь угтаа пролетарийн интернационализм, бүх үндэстэн ард түмэн эрх тэгш байх лениний үзэл санаа амьдралд хэрэгжин биелсэний түүх, тус хоёр орон дэлхийн түүхэнд анх удаа улс хоорондын харилцааны социалист хэв маягийн үлгэр дууриалыг үзүүлж дэлхийн социалист нөхөрлөлд цаашдынхаа хөгжлийг олсоны түүх мөн. Манай хоёр ард түмний найрамдал түүхийн гүн үндэс сурвалжтай бөгөөд мөнхүү үндэс нь октябрийн хувьсгалын ялалтаас бүр өмнө хаант Оросын дарлагч анги, хаант засгийн колонийн бодлоготой харгалдан буй болсон юм.

Хаант засгийн империалист бодлого нь Орос, Монголын Хөдөлмөрчдийн сайн хөршийн найрсаг харилцааг сааруулж чадаагүй билээ.

Ф. Энгельс, Орос нь Дорно дахинд дэвшилтэт үүрэг гүйцэтгэснийг өгүүлж байлаа. Үнэхээр ч Оросын гүйцэтгэх үүрэг түүнтэй хөрш зэр гэлдээ Гадаад Монголын хувьд онцгой ач холбогдолтой байсан нь илэрхий. XIX зууны сүүлч XX зууны эхэн үеийн Орос-Монголын харилцааг бүхэлд нь судалсан зөвлөлт, Монголын эрдэмтэд өөрсдийн судалгаандаа,¹ хувьсгалын өмнөх Монголын эдийн засагт Оросын худалдааны капитал мөлжигч үүрэг гүйцэтгэж байсан хэдий ч Орос нь Монголын ард түмний аж ахуй, соёлын хөгжилд тодорхой дэвшилтэт үүргийг гүйцэтгэж байлаа гэж бодитойгоор тэмдэглэжээ. 1917 оны Октябрийн хувьсгал хүртэлх Орос-Монголын харилцааг тодорхойлох гол зүйл нь Оросын ард түмний феодалын Монголынхоос илүү өндөр соёлын нөлөө байлаа. Хаант Оросоос жич өөр Орос-Дэлхийд хамгийн хувьсгалч ажилчин анги, большевик нам бүхий Оросоос Монголд дэвшилтэт хувьсгалт үзэл санаа нэвтэрч байв.

XIX зууны сүүлч XX зууны эхээр дэлхийн хувьсгалт хөдөлгөөний төв Орос оронд шилжиж, Оросын түүхийн дэвшилтэт нөлөөний гол, тодорхойлогч хүчин зүйлүүд Монгол болон Дорно дахины бусад улс оронд буй боллоо. Орос ленинизмийн эх орон болов.

Хувьсгалт оросын пролетари нар, большевик намыг Монголын хөдөлмөрчид үнэнч хань нөхөр, найдвартай холбоотноо болголоо. Монголын ард түмний чөлөөлөх тэмцэл нь Орос дахь пролетарийн хөдөлгөөнтэй тасралтгүй холбоотой байв.

В. И. Ленин тэргүүтэй большевикуудын нам Монголын талаарх хаант засгийн түрэмгий бодлогыг шийдвэртэй эсэргүүцжээ. 1916 онд Дэлхийн I дайн ид өрнөж байхад, Ленин: «...Их Оросын ажилчин ард засгийнхаа газрыг Монголоос зайл гэж шаардах ёстой.»² гэж бичиж байлаа. Ленин тэргүүтэй большевикууд, Дорно дахины дарлагдсан ард түмэн, түүний дотор Монголын ард түмний эрх чөлөөний тэмцлийг халуунаар дэмжиж байсан юм. В. И. Ленин октябрийн хувьсгалын өмнө: «Бид бол монгол, перс, энэтхэг, египетчүүдтэй ойртон нийлэхийг бүх хүчээрээ чармайх бөгөөд эс тэгвэл Европ дахь социализм батгүй болох тул ингэхийг өөрийн үүрэг, өөрийн эрх ашиг гэж бид үзэж байна. Биднээс илүү дарлагдан хоцрогдсан эдгээр улс түмэнд «соёлын тусламжийг сэтгэл харамгүй» үзүүлэхийг Польшийн сиал-демократуудын хэлсэн сайхан үгээр буюу өөрөөр хэлбэл, машин хэрэглэх, хөдөлмөрөө хялбарчлах, социализмд тэднийг шилжихэд нь туслахыг бид хичээнэ»³ гэж бичжээ.

Октябрийн хувьсгалын ялалтаар Зөвлөлт Орос нь бүх ард түмэн эв найрамдалтай, ахан дүүсэг, харилцан ойлголцох ленинч зарчимд түшиглэн бусад улс орнуудтай харилцах шинэ харилцааг бий болгов. 1917 оны 11-р сарын 20 (12-р сарын 3-нд Зөвлөлт засгийн газраас Орос болоод Дорно дахины бүх хөдөлмөрчид-мусульман шашинтан нарт хандаж гаргасан тунхаглалд Дорно дахины улс орныг колони, хараат байлгах талаар хаант Оросоос империалист бусад гүрнүүдтэй тогтоосон нууц, эрх тэгш бус гэрээнүүдийг устгах болсон тухайгаа мэдэгджээ.

1917 оны Октябрийн хувьсгал нь Монголын ард түмний эрх чөлөөний төлөө тэмцэлд шийдвэрлэгч үүрэг гүйцэтгэсэн юм.

Орос-Монголын харилцааны түүхэнд шинэ хуудас нээгдлээ.

Орост болсон хэрэг явдлын тухай үнэн Монголын умард хил хязгаар, улс орны төвд янз бүрийн замаар тархав. Зөвлөлт Оросын засгийн газар бүр Октябрийн хувьсгал ялангуут л Монголын засгийн газартай холбоо тогтоохыг оролдсон юм. 1918 оны 3-р сард гадаад хэргийн ардын комиссар Г. В. Чичерин Монголын засгийн газарт цахилгаан илгээж, хаант Оросын бүх төлөөлөгчдийг албан тушаалаас нь зайлуулсан ба Зөвлөлт засгийн газрын цорын ганц хууль ёсны төлөөлөгч нь Өргөө (Нийслэл Хүрээ)-д Васильев (уг хүн нь цахилгаан Мэдээч, түүнийг Монгол дахь Зөвлөлтийн засгийн газрын төлөөлөгч болгохыг Троицкосавскийн зөвлөл санал болгожээ) байх болно гэж заажээ. Гэлээ ч Монголын харгис эрх баригчид Оросын дипломат төлөөлөгч байсан Орловтой харилцаар байлаа.⁴ Монголын засаг төр Зөвлөлт Оросоос тэргүүний хувьсгалт үзэл санаа нэвтрэн орох арга замыг хаах гэж элдвээр оролдож байв. Хаалт хамгаалалт цөм байсан хэдий ч Оросын хэрэг явдлын үнэн Монголын өргөн уудам нутгаар түгэн тархлаа. Хоёр орны ард түмний найрамдлыг засаг захиргааны

аливаа аргаар хязгаарлан хориглох бололцоогүй болжээ. Октябрийн хувьсгалын үзэл санаа Монголд дэлгэрэх нэн таатай нөхцөлийг тэнд байсан оросын ажилчин, ажилтан, цэргүүд бүрдүүлж байв. Тухайн үед Хүрээний Орос хороо (цуваа) -нд 3000 орчим хүн байсан ба Оросын цувааны хувьсгалт гол хүчний илүү идэвхтэй төлөөлөгчид нь М. И. Кучеренко, Я. В. Гембаржевский, И. С. Маслаков нар болж байжээ. Монголын малчин ардын төлөөлөгчдийн үзэл санаа нэн хувьсгалч бөгөөд тэд нар Октябрийн хувьсгалын зорилго, зорилтыг бүдэг бадаг тоймлож байсан мөнхүү үед Оросын хувьсгалчдын үйл ажиллагаа маш чухал байсан юм.

1919 оны VШ сард Зөвлөлт Оросын засгийн газар интернационализмд үнэнч зарчмаар, Монголын ард түмэнд тусгай илгээлт бичиг явуулжээ. Уг бичигт: «Зөвлөлтийн засгийн газар: Оросын ард түмэн Монголын тухай Япон, Дундад хоёр улс лугаа урьд хааны үед тогтоосон аливаа гэрээ зүйлийг цөм устгасны учир, үүнээс хойш Монгол улс бол өөртөө эрхт тусгаар нэгэн орон мөн бөгөөд тэр тул Оросын зөвлөх түшмэл, хааны консулууд, банкны эзэд, их хөрөнгөтөн сэлтээр хар хүчний сүр, мөнгө зоос хоёроор монголчуудыг гартаа базан атгаж байв. .. иймээс Монголын хязгаараас хөөн гаргавал зохимой. Засгийн бүрэн эрх ба шүүх таслах хэргийг цөм Монголын хязгаар дотор гагцхүү Монгол улс өөрөө эрхлэн мэдвээс зохимой. Монголын дотоод хэрэгт ямар ч гадаадын хүмүн нар оролцох эрх үгүй гэж дахин өндөр дуугаар өргөмжлөн мэдэгдэж байна» хэмээн дурьджээ.⁵

Монголын хувьсгалчид эх орноо чөлөөлөх тэмцлийн анхан үеэс эхлэн Зөвлөлт Орос улсад хандсан бүлгээ. Тэдэнд Зөвлөлүүдийн орны дэмжлэгийг олж авах нь зайлшгүй шаардлагатай зүйл байлаа. 1920 оны зун долоон хүний бүрэлдэхүүнтэй (Сүхбаатар, Чойбалсан, Данзан Бодоо, Догсом, Лосол, Шагдаржав) Монголын төлөөлөгчид Зөвлөлт Орост очихоор морджээ.

Бидэнд байгаа архивын баримтууд уг асуудлын зарим талыг тодотгож чадах юм. Төлөөлөгчдийн гишүүд нууц ажил явууллагын дүрэм журмыг сахиж Хүрээнээс гурван хэсэг болон гарсан нь тодорхой байна. Чойбалсан, Данзан нар 7-р сард, Бодоо, Шагдаржав хоёр 8-р сарын 2-нд, Сүхбаатар, Догсом, Лосол нар 1920 - оны 8-р сарын 6-нд тус тус Хүрээнээс гарчээ. Монголын төлөөлөгчдийг Зөвлөлт Оросын гадаад хэргийн ардын комиссириатын бүрэн эрхт төлөөлөгч Отто Иванович Макстенек Троицкосавск хотноо халуун дотноор хүлээн авсан байна. Төв Хорооны Алс дорнодын товчооны нэр дээр түүний явуулсан мэдээнд Алс дорнодын Бүгд Найрамдах Улсын хил хязгаараар нэвтэрсэн Монгол ардын намын хоёр төлөөлөгч-Чойбалсан, Данзан нарын тухай өгүүлжээ.⁶ Захидалд Монгол ардын нам нь аман программтай бөгөөд ард түмний амьдралыг дарлал мөлжлөггүйгээр цогцлон байгуулахыг эрмэлзэж байна хэмээн заасан байна.⁷ Тэр үеийн өөр нэгэн баримтад (Зөвлөлт Оросын гадаад хэргийн ардын комиссириатын бүрэн эрхт төлөөлөгч Макстенекээс ТХ-ны Алс дорнодын товчооны нэр дээр 1920 оны 8-р сарын 7-нд ирүүлсэн захидал): «. . Ирсэн гурван төлөөлөгчид нь иргэн Дэмбэрэл (Догсомын нууц нэр Д.У), Тау-га (Лосолын нууц нэр Д.У), Сүхбаатар зэрэг монгол ардын хувьсгалт намын гишүүд болно. Тэд Монголын ямар нэгэн вангаас нөхөр Ленинд хүргэх захидлыг авч явна хэмээн мэдэгдэв»⁸ гэж өгүүлжээ.

1920 оны 8-р сард Монголын төлөөлөгчид Эрхүү-д хүрэлцэн ирлээ. Монгол дахь улс төрийн байдал түгшүүртэй, хувьсгалт тэмцлийг цаашид дэлгэрүүлэх шаардлагатай харгалзан төлөөлөгчдийн нэг хэсэг нь Зөвлөлтийн засгийн газартай хэлэлцээ хийхээр Москва-г зорьж, нөгөө хэсэг нь Монгол дахь хувьсгалын ажлыг үргэлжлүүлэхээр Нийслэл Хүрээ рүү одов. Москва явсан Төлөөлөгчидтэй холбоо барих, Монгол дахь хувьсгалт хөдөлгөөнийг удирдах зорилгоор Сүхбаатар, Чойбалсан нар Эрхүүд хоцорлоо. Тэд Оросын коммунист нам, ажилчин ангийн хувьсгалт туршлагатай энд танилцжээ. Сүхбаатар энд байхдаа Оросын коммунист (б) намын Эрхүүгийн (мужийн) III бага хурлын ажиллагаанд оролцжээ. Хурлын төлөөлөгчдөд хандаж Сүхбаатар хэлэхдээ: «Миний бие, дэлхийн капиталын эсрэг бослогын тугийг эн тэргүүнээ өргөн мандуулсан Оросын коммунист намын Эрхүүгийн бага хуралд тэндээс (Монголын малчдаас-орч) баяр хүргэж ирэв. Лам ноёд, Хятадын цэргийн эрхтэн, дэлхийн капиталын гурван давхар талхигдалд нэрвэгдсэн Монголын онгон хээр талын малчдад танай намын уриа хүрсэн юм. Оросын коммунист хувьсгал Дорно дахинд хувьсгалын түймрийг ноцоолоо. Дорно дахины ард түмэн тэмцэлд босож байна»⁹ гэжээ.

1920 оны 11-р сарын 10-наас анхны дугаар нь «Газар бүрийн ардууд нэгдэгтүн» хэмээх уриалгатайгаар хэвлэгдсэн Эрхүү дэх намын нууц сонин «Монголын үнэн» Сүхбаатар болон бусад хувьсгалчдын нэртэй холбоотой. Тус сонин хувьсгалт хэвлэлийн эх үүсвэрийг тавьж, ардын хувьсгалт намыг буй болгоход ихээхэн үүрэг гүйцэтгэсэн юм. Уг сонин Троицкосавскаар дамжин Монголд тараагдаж байв. Троиц косавск нь Алс дорнод дахь Коминтерны нарийн бичгийн дарга нарын газар, Зөвлөлт Орос, Монголын хувьсгалчдын харилцааны зангилаа газар болж байв.

1920 оны 11-р сарын 16-нд Монголын төлөөлөгчид Москвагаас Эрхүүд хүрэлцэн ирлээ. Тэд Сүхбаатар, Чойбалсан нарт Зөвлөлт төрийн удирдагчидтай хийсэн хэлэлцээрийнхээ үр дүнгийн тухай тодорхой мэдээлжээ. В. И. Ленин Монголын төлөөлөгчидтэй уулзаж үнэт зөвлөлгөө өгөхдөө, «Танай орны хөдөлмөрчдөөс төрийн болоод аж ахуйн тусгаар тогтнолынхоо төлөө тэмцэх ганц зөв зам бол Зөвлөлт Оросын ажилчин, тариачинтай холбоо байгуулах явдал мөн»¹⁰ хэмээн сургажээ. В. И. Ленин Монголын хувьсгалын эх үүсвэрийг хамгаалан, түүний хөгжлийн явцыг онцгой анхааралтай ажиглаж байлаа.

1920 оны сүүлчээр Монгол дахь феодал-лам нарын засаглал гүнзгий хямралд өртөв, Улс орныг Хятадын милитарист цэргүүд, дараа нь Барон Унгерний цагаан гвардийн дээрэмчид түрэмгийлэн эзлэхэд засаг төрийн эрх баригчид улс төрийн дампууралд орж, Монголын ард түмний үндэсний эрх ашгаас урвасан нь илт боллоо. Эзлэн түрэмгийллийн харгис дэглэм нь Монголын ард түмэнд барагдашгүй гамшиг учруулахын сацуу үндэсний ухамсрыг өсөн нэмэгдэхэд түлхэц болов.

1921 оны 3-р сарын 1-3-нд Троицкосавск хотноо Монгол ардын хувьсгалт намын анхдугаар их хурал хуралджээ. Их хурлын шийдвэрт өнөөгийн болоод хожимын аугаа эх зорилгодоо хүрэхийн тулд Зөвлөлт Орос улстай ах дүүгийн найрамдал, нягт нөхөрлөлийн харилцааг тогтоох тухай өгүүлсэн байна.¹¹ МАХН-ын анхдугаар их хурал, Коминтерны байнгын төлөөлөгчдийг Монголд суулгахаар урьсан нь зарчмын ач холбогдолтой болсон бөгөөд манай нам коммунист интернациона-

лын үзэл суртлын удирдлагыг хүлээн дагаж буйг гэрчлэн харуулав. Их хурлын дараа манай нам коминтернд зөвлөх эрх бүхий талархагч секц болон элсжээ.¹² МАХН байгуулагдсан нь Монголын ард түмний эрх чөлөөний тэмцэлд эргэлтийн үе боллоо. 1921 оны ардын хувьсгалын ялалтаас өмнө Д. Сүхбаатар тэргүүтэй Монголын хувьсгалчид Зөвлөлт Оростой холбоо тогтоов.

Орос хэлнээс товчлон
орчуулсан Ч. Эрдэнэбаяр.

¹ **Майский И. М.** Монголия накануне революции», М., 1959. «История Монгольской Народной Республики (издание третье, переработанное и дополненное) М., 1983, **Пунцагноров Ц.** Монголын автономит үеийн түүх, 1955, **Б. Лигу.** Из истории русско-монгольских отношений в конце XIX-в начале XX в. (автореферат канд. диссер.), 1960. и др.

² **В. И. Ленин**, Полн. собр. соч., т. 30, с. 119

³ **В. И. Ленин**. Полн. собр. соч., т. 30, с. 120

⁴ **См. :Капица М. С., Иваненко В. И.** Дружба, завоеванная в борьбе, М.Международ. отношения, 1965, с. 13

⁵ Монгол Ардын Хувьсгалт Намын түүхийн зарим чухал баримтууд. УБ., 1946, с. 64—65

⁶ См.: ЦПА ИМЛ при ЦК КПСС, ф. 372, оп. 1, д. 31: л. 2

⁷ См.: Там же

⁸ См.: Там же

⁹ Партархив Иркутского ОК КПСС, ф. 1, оп. 1, д. 3, л. 2

¹⁰ Ленинский сборник. т. 35, М., Политиздат, 1945, с. 290

¹¹ «Общественные науки МНР», № 2, Улан-Батор, 1981, с. 49

¹² Некапиталистический путь развития и опыт Монгольской Народной Республики. М., Мысль, 1971, с. 72

АЗИ, НОМХОН ДАЛАЙН БҮС НУТАГ АЮУЛ ЗАНАЛ, АЮУЛГҮЙ БАЙДАЛ

Ш. САНДАГ

Түүхийн ухааны доктор

1980-аад дунд үеэр олон улсын харилцааг зааглан авч үзэх нь зүйтэй мэт бодогдоно. Учир нь ЗХУКН-ын XXVII их хурал, дэлхий ертөнцийг 2000 он гэхэд цөмийн зэвсгээс ангижруулах тухай Зөвлөлтийн санал, дунд болон ойр тусгалын пуужин устгах тухай Зөвлөлт-Америкийн гэрээ зэрэг томоохон үйл явдлууд гарсан нь шинэ сэтгэлгээний үр дүн бөгөөд дэлхийн түүхнээ шинэ зааг бий болголоо.

Дайн энхийн асуудлын үүднээс авч үзвэл олон улсын байдал ямагт хурцадсаар цөмийн дайны аюул босгон дээр тулж ирснийг сэрэмжлэн зайлуулж, буцааж хариулж болох юм гэдгийг 1980-аад оны дунд үе